

Н.Батзаяа: Түүхий сүүгээр жилийн дөрвөн улиралд тараг үйлдвэрлэхээр ажиллаж байна



Өнөөдөр хэрэглэгчдийн төлөөлөл болон сэтгүүлчид “Оргил хүнс” ХХК-ийн үйлдвэрлэдэг “Гоё тараг”-ны үйлдвэртэй танилцлаа. Сүүлийн үед тус компаниас үйлдвэрлэн гаргадаг “Гоё тараг”-ийг Хятад улсад үйлдвэрлэж импортоор оруулж ирдэг гэх мэдээлэл цацагдах болсон. Тэгвэл “Оргил хүнс” ХХК-ийн зүгээс энэхүү мэдээллийг няцаах үүднээс “Гоё тараг” үйлдвэрлэлийн ямар шат дамжлагаар дамжин хэрхэн эцсийн бүтээгдэхүүн болж байгааг иргэдийн төлөөлөлд танилцуулж, үйлдвэрээ үзүүлсэн юм.



Тэд юун түрүүнд хэрэглэгч бол бидний хамгийн үнэ цэнэтэй зүйл хэмээн онцлоод, улс орондоо үйлдвэрлэж байгаа томоохон ажлыг маань өөр улсад үйлдвэрлэсэн бэлэн бүтээгдэхүүн авчирч худалдаалдаг мэтээр гүтгэж байгааг сэтгэл дундуур байгаагаа илэрхийллээ.

Саявтархан “Гоё тараг”-ийг Хятад улсаас оруулж ирдэг гэх мэдээлэл агуулсан зураг фэйсбүүк сүлжээгээр олон нийтэд цацагдсан. Тэгвэл тэрхүү зургийн тайлбарыг тэд мөн хийлээ. Тодруулбал, урд хөршөөс бус Төмөр замын вокзалын баруун талд байрлах “Ногоон зоорь” гэж нэрлэгддэг орон нутаг руу бараа ачдаг ачилтын талбай дахь воганаас бараа худалдан авч буй зураг ажээ. Үүнийг нотлох воган ачилтын төлбөр тооцооны баримтыг мөн дэлгэн үзүүлсэн юм. Түүнчлэн “Оргил хүнс”-ийнхэн гарсан мэдээлэлтэй холбоотойгоор МХЕГ-ын Хилийн мэргэжлийн хяналтын газар, Хан-Уул дүүргийн МХГ, ГЕГ-ийн статистикийн алба зэрэг газруудад зохих лавлагаа авах хүсэлтээ өгчээ.

Сайтын их уншсан Шинэ мэдээ

-  **Салсандаа хорсож хариугаа ингэж авчээ**
-  **Г.Жуков – цэргийг хайрлах хэрэг юун**
-  **Малайзийн онгоцны эрэлд нэмэлт хөрөнгө гаргаа мэдэгдэв**
-  **Х.Тэмүүжин сайд Б.Билэгтээс айв уу, Ерөнхийлөгчөөс айв уу**
-  **Б.Насанбаярыг сайд Л.Гантөмөр нь яагаад халдаггүй вэ**
- Ам.долларын ханш өсчээ**
- Какүрюү Ананд Ёкозуна цолны болзолгүй хангалаа**
- Наурызын баярын парад болов**
- Монголын хоккейчид хүрэл медаль хүртлээ**
- Машин ачилтынхны хэтэрхий ашиг харж, улайрсан байдал хэрээс хэтэрлээ**
- Аймгийн хурц арслан Ч.Батчулуун түрүүллээ**
- “Буянт ухаа-1” хорооллын бүртгэл өнөөдөр дуусгавар болно**
- УИХ-ын дарга З.Энхболд Баян-Өлгий аймагт ажиллаж байна**
- 3000 айлын орон сууц ашиглалтад оруулна**
- Казах түмэн Чингисийн талбайд баяраа тэмдэглэв**
- “Шүүрс” хэмээх номыг шүүрс алдаж уншаад...**
- Гамшгийн үеийн үзүүлэх сургуулилт боллоо**
- Сурагчид энэ сарын 29-нд амарна**
- “11 11 төв”-д энэ долоо хоногт нийт 828 санал хүсэлт иржээ**
- “Номонд дурлагсдын өдөрлөг” зохиогдож байна**
- “Бүсгүйн урлан-2014” үзэсгэлэн худалдаа явагдаж байна**
- “Арева Монгол”-оос мэдээлэл хийнэ**
- Ялалт байгуулахад минь туслаач**
- Улаанбаатарт 10-12 градус дулаан**
- Монголын эдийн засгийн форум маргааш эхэлнэ**
- Зам барилгын ажил эхэллээ**

слах
ий
зар

Тань
В



“Гоё тараг”-ны үндсэн түүхий эд болох шингэн сүүг Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өлзийт тосгонд байрладаг “Атар чандгана сүү” ХХК-аас худалдаж авдаг аж. Ерөнхийдөө “Гоё тараг”-ыг урд хөршөөс оруулж ирдэг гэх мэдээлэл бол зориуд санаатайгаар бэлтгэсэн мэдээлэл хэмээн тэд үзэж байна. Учир нь “Сүүн бүтээгдэхүүн хэрэглэгчдийн төв” ТББ-ийн тэргүүн н.Цэрэн гэгч хагас жилийн өмнөөс “Оргил хүнс” ХХК-ийн нэр хүндэд халдаж байжээ. Тэгвэл сүүлийн үед гараад байгаа мэдээлэл өмнө н.Цэрэнгийн бэлтгэсэн мэдээлэлтэй яг адилхан гэдгийг мөн дуулгасан.

“Гоё тараг” ны үйлдвэртэй танилцах явцад “Оргил хүнс” ХХК-ийн захирал Н.Батзаяатай уулзаж зарим асуултад хариулт авлаа.

- Сүүлийн үед танайхаас үйлдвэрлэн гаргадаг “Гоё тараг”-ны талаар нилээд асуудал гарах боллоо. Энэ талаар тайлбар өгөхгүй юу?

- Энэ бол удаан үргэлжилж байгаа асуудал. Бид өмнө нь хэвлэлийнхэнд ханддаггүй байсан. Нэг хүний явуулгаар удаа дараа манай компанитай холбоотой асуудлаар мэдэгдэл хийгээд бараг хоёр жил шахам болж байна. Манайх үйл ажиллагаагаа явуулаад олон жил болж байгаа тогтворжсон компани. Энэ хугацаанд тэр хүний явуулгаар Мэргэжлийн хяналт, бусад холбогдох газраас байнгын шалгалт хийдэг. Энэ бүхэнд үнэн мөнийг тогтоолохоор бид шүүхэд хүртэл хандаж байсан удаатай. Түүнээс манайх Хятадаас тараг оруулж ирээд савлах юмуу, эсхүл Хятад улсад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг импортоор оруулж ирэн худалдаалдаг жижиг аж ахуйн нэгж биш. Бүр бүтээгдэхүүнийхээ чанарын баталгааг дэлхийд таниулсан Шинэ Зеландаас тарагны найрлагад ордог бүтээгдэхүүнээ авчирдаг. Мөн Данийн “Хансен” компаниас тарагны хөрөнгөө, АНУ-гийн Каргелл-аас тогтворжуулагч нэмэлт бүтээгдэхүүнээ авдаг. Баталгаатай нарийн технологиор ард иргэддээ чанартай тараг үйлдвэрлэхийг зорьж ирсэн, хойшид ч энэ тал дээр бүр Монголынхоо түүхий эдээр үйлдвэрлэх зорилт тавин ажиллаж байна.



- Түүхий эдээ хөдөө орон нутгаас татдаг гэсэн?


- Манай “Витафит” группийн охин компаниуд олон. Тэдний нэг нь Хэнтий аймгийн Хэрлэн сумын нутагт хуучнаар Чандаганы САА-г сэргээн 400 гаруй үхэртэй саалийн ферм байгуулаад гурван жилийн нүүр үзэж байна. Эндээс түүхий эдээ авдаг. Бас одоохондоо 100 хувь хангаж чадахгүй байгаа болохоор дээр хэлсэн гадаадын чанарын шаардлага хангасан олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хуурай сүүгээр “Гоё тараг”-аа үйлдвэрлэдэг. Түүнээс дан ганц хуурай сүүгээр тараг үйлдвэрлэнэ гэж байхгүй.

- Цаашид хуурай сүү хэрэглэхгүйгээр дан ганц түүхий сүүгээр тараг үйлдвэрлэх боломж байгаа юу?

-Түүхий сүүгээр жилийн дөрвөн улиралд тараг үйлдвэрлэхээр бид ажиллаж байна. Манай материаллаг бааз болох сүүний фермийн маань үнээний тоо 400 гаруй гээд их юм шиг сонсогдож байгаа ч зарим нь тугаллана, тэгээд асаргаа маллагаа гээд олон асуудал байдаг. Энэ бүхнийг зохицуулж, хүчин чадлаа улам нэмэгдүүлэхийн тулд бид ажиллаж байна. Савалгаа хүртэл нарийн технологитой. Энэ бүхнийг мэдэхгүй хүмүүс биднийг энд тэндээс Хятад гэсэн хаяг нэр зүүн хэвлэлээр тарааж байгаад л харамсаж байна.

- Танай “Гоё тараг”-ны сав Хятадаас орж ирдэг талаар өмнө нь сонсож байсан. Гэтэл бодит байдал дээр нь танилцаад үгүй юм байна гэдгийг мэдлээ.

-Тийм шүү. Манайх өөрийн үйлдвэр дотроо тарагнийхаа савийг үйлдвэрлээд тодорхой шат дамжлага, горимын дагуу газар дээр нь бэлэн болсон таргаа савлаж байгааг та бүхэн нүдээрээ харлаа. Мөн манай тарагны сав хаягдал болдоггүй. Байгальд ямар нэгэн хор нөлөөгүй гэдгээрээ онцлог.











Р.Оргил

Мэдээний линк: <http://society.time.mn/content/42165.shtml>

Эхлэл хуудас руу үсрэх

LIKE дарж дэмжээрэй.

Like Share 20,639 people like this. Sign Up to see what your friends like.

Түгээх

Like Shar Tweet 1 Түгээх 0

Share 62 Follow @timemn

